



Сонгуулийн хуулиуд дахь хэвлэл мэдээлэлтэй холбоотой заалтууд

2010 оны 11 сарын 19
Улаанбаатар хот

Сонгуулийн хуулиуд

- Сонгуулийн төв байгууллагын тухай хууль
- Ард нийтийн санал асуулгын тухай хууль
- Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн хууль
- Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хууль
- Орон нутгийн хурлын сонгуулийн тухай



Ард нийтийн санал асуулгын тухай хууль

9 дүгээр зүйл. Санал асуулга бэлтгэн явуулах ажлын ил тод байдал

- 2. Төрийн байгууллагын харьяалал бүхий хэвлэл, мэдээллийн байгууллага санал асуулга бэлтгэн явуулах ажлын явц, санал асуулгын дүнг олон нийтэд шуурхай, үнэн зөв мэдээлэх үүрэгтэй.



17 дугаар зүйл. Санал асуулгын талаар явуулах ухуулга, сурталчилгаа

- Санал асуулгаар тавигдаж байгаа асуудлын талаар ард нийтэд таниулах, мэдээллээр хангах **асуудлыг төр хариуцна.**




Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн хууль

**6 дугаар зүйл. Сонгууль бэлтгэн
явуулах ажлын ил тод байдал**

- **2. Хэвлэл, мэдээллийн байгууллага
сонгууль бэлтгэн явуулах ажлын
явц, сонгуулийн дүнг олон нийтэд
шуурхай мэдээлэх үүрэгтэй.**


*/Энэ хэсэгт 2001 оны 02 дугаар сарын 01-ний
өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан/*


- 
- 3. Сонгуулийн ерөнхий хороо нь Ерөнхийлөгчид нэр дэвшүүлсэн нам, хамтарсан намууд, нэр дэвшигч **улс даяар үйл ажиллагаа явуулж байгаа** бүх радио, телевизээр төлбөртэй болон төлбөргүй явуулах нэвтрүүлгийн хугацаа, боломж нь адил байхаар тооцон, хуваарь хийж, санал авах өдрийг товлон зарласнаас хойш 15 хоногийн дотор батална. Ерөнхийлөгчид хамтарч нэр дэвшүүлсэн намуудыг нэг субъект гэж үзнэ.
 - **Улс даяар үйл ажиллагаа явуулж** байгаа бүх радио, телевизээр Сонгуулийн ерөнхий хорооны баталсан хуваарьт зааснаас өөр төлбөртэй ба төлбөргүй нэвтрүүлэг явуулж үл болно. /Энэ хэсэгт 2009 оны 01 дүгээр сарын 16-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан/



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН СОНГУУЛИЙН ТУХАЙ

- 37.4. Сонгуульд оролцож байгаа нам, эвсэл, нэр дэвшигч нь мөрийн хөтөлбөрөө танилцуулсан хоёр хэвлэлийн хуудас бүхий хоёр сонин, хэвлэл, нэг хэвлэлийн хуудас бүхий нэг ухуулах болон зурагт хуудас, нэр дэвшигчийн намтар, бусад сурталчилгааны материалыг нэг хэвлэлийн хуудаст тус тус багтаана.
- 37.5. Энэ хуулийн 37.4-д заасан хязгаарлалтын дүнг хэвлэмэл байдлаар сонгогчдод тараах бүх төрлийн хэвлэлийн нийлбэрээр тооцно.

- 
- 37.7. Олон нийтийн радио, телевиз нь төлбөртэйгээр сонгуулийн аливаа сурталчилгаа явуулахгүй бөгөөд Сонгуулийн ерөнхий хорооноос тогтоосон хуваарийн дагуу **төлбөргүй сурталчилгаа явуулна.**
 - 37.8. Сонгуулийн ерөнхий хороо нь олон нийтийн радио, телевизээр төлбөргүй явуулах сурталчилгааны хуваарийг батлахдаа нам, эвсэл бүрт, түүнчлэн нэг тойрогт өрсөлдөж байгаа нэр дэвшигч бүрт тэнцүү хугацаа ногдохоор тооцож, холбогдох шийдвэрийг гаргана.




37.9. Олон нийтийн радио, телевизээс бусад радио, телевизээр сонгуулийн сурталчилгааг төлбөртэй явуулах бөгөөд төлбөртэй сурталчилгааны нийт хугацаа тухайн радио, телевизийн нэвтрүүлгийн нийт хугацааны 10 хувиас хэтрэхгүй байна.


37.7. Олон нийтийн радио, телевиз нь төлбөртэйгээр сонгуулийн аливаа сурталчилгаа явуулахгүй бөгөөд Сонгуулийн ерөнхий хорооноос тогтоосон хуваарийн дагуу төлбөргүй сурталчилгаа явуулна.



Орон нутгийн сонгуулийн тухай хууль

- 30.7.Орон нутгийн радио, телевизээр сонгуулийн аливаа сурталчилгааг төлбөргүй явуулах хугацаа, хуваарийг тухайн аймаг, нийслэл, сум, дүүргийн сонгуулийн хороо тогтооно.
- **30.9.Олон нийтийн радио, телевизээр орон нутгийн Хурлын сонгуулийн аливаа сурталчилгаа явуулахыг хориглоно.**

- 
- 30.10.Сонгуулийн хорооноос тогтоосон хугацаанаас бусад цагт нэр дэвшигч, нам, эвсэл орон нутгийн болон орон нутагт нэвтрүүлгээ цацаж байгаа энэ хуулийн 30.9-д зааснаас бусад төвлөрсөн радио, телевизээр төлбөртэй сурталчилгаа явуулах эрхтэй.

- 
- 30.17. Аймаг, нийслэл, сум, дүүргийн сонгуулийн хороод нь **сурталчилгааны тэнцвэрт байдалд олон нийтийн оролцоотойгоор хяналт тавьж, энэ асуудлаар нам, эвсэл, нэр дэвшигч, бусад байгууллага, иргэдээс ирүүлсэн өргөдөл, гомдлыг шуурхай хянан шийдвэрлэнэ.**

/Энэ хэсгийн дугаарт 2008 оны 5 дугаар сарын 6-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан!

Сонгуулийн төв байгууллагын тухай хууль

- **14 дүгээр зүйл. Хэвлэл мэдээллийн зөвлөл**
- 14.1.Хороо сонгуулийн үеэр дэргэдээ хараат бус хэвлэл мэдээллийн орон тооны бус зөвлөл байгуулж ажиллуулна.
- 14.2.Хэвлэл мэдээллийн зөвлөл нь хэвлэл, мэдээллийн мэргэжлийн байгууллага, төрийн бус байгууллагын төлөөлөл болон сонгуульд оролцож буй нам, эвслийн тэгш төлөөллөөс бүрдсэн байна.
- 14.3.Хэвлэл мэдээллийн зөвлөл нь нам, эвсэл, нэр дэвшигчийн хэвлэл мэдээллийн сурталчилгааны тэнцвэрт байдалд хяналт тавих бөгөөд энэ асуудлаар нам, эвсэл, нэр дэвшигч, хуулийн этгээд, иргэнээс ирүүлсэн өргөдөл, гомдлыг хянан үзэж, санал дүгнэлт гаргаж Хороонд танилцуулна.
- 14.4.Хэвлэл мэдээллийн зөвлөлийн бүрэлдэхүүн, ажиллах журмыг Хороо тогтооно.



ДҮГНЭЛТ

- *Бусад хууль тогтоомжийг боловсронгуй болгох*
- *ХМХ-ийн үйл ажиллагааг зохицуулсан зарим хуулийг шинээр батлах шаардлагатай*



Хууль хэрэглэхэд гарсан хүндрэл

- 37.9.Олон нийтийн радио, телевизээс бусад радио, телевизээр сонгуулийн сурталчилгааг төлбөртэй явуулах бөгөөд төлбөртэй сурталчилгааны нийт хугацаа тухайн радио, телевизийн нэвтрүүлгийн нийт хугацааны 10 хувиас хэтрэхгүй байна.
- Радио, телевизийн нэвтрүүлгийн нийт цагийн 10%-ийн хязгаарлалтыг заахдаа тухайн нэг өдрийн, эсвэл сонгуулийн сурталчилгааны нийт цаг алин болох нь тодорхойгүй байв.



Хууль хэрэглэхэд гарсан хүндрэл

- Нам, эвсэл бүрт, түүнчлэн нэг тойрогт өрсөлдөж байгаа нэр дэвшигч бүрт сурталчилгааны тэнцүү хугацаа олгохоор заасан нь “Нам, эвсэл, нэр дэвшигчийн сонгуулийн сурталчилгааг нэр дэвшигч бүртгүүлж, үнэмлэх авсан өдрөөс эхлүүлнэ” гэсэнтэй зөрчилдөж байв.



Хууль хэрэглэхэд гарсан хүндрэл

- Нам, эвсэл бүрт, түүнчлэн нэг тойрогт өрсөлдөж байгаа нэр дэвшигч бүрт сурталчилгааны тэнцүү хугацаа олгохоор заахдаа энэ нь радио, телевизийн нэг суваг, эсвэл сурталчилгааны туршид хот, хөдөөгийн нийт радио, телевизийн сувгаар руу гэдэг нь ойлгомжгүй.



Хууль хэрэглэхэд гарсан хүндрэл

- МҮОНРТ-ээс бусад радио, телевизэд сонгуулийн сурталчилгааг зөвхөн төлбөртэй явуулахаар заасан байв.

Гэхдээ төлбөрт сурталчилгааг заавал онцлох, тодотгох талаар аливаа зүйл заалт байхгүй.



Хууль хэрэглэхэд гарсан хүндрэл

- Кампанит ажлын албан ёсоор эхлэх хугацааг тогтоосон ч тодорхой өдөр заагаагүй, сурталчилгааны нийт хугацаа тодорхой зохицуулалтгүй, мөн сонгуулийн товыг зарлахаас өмнө ухуулга сурталчилгааг ил, далд хэлбэрээр явуулсан бүх тохиолдолд эргээд хариуцлага тооцох эрх зүйн механизм байхгүй байсан нь сонгуульд өрсөлдөгч, нэр дэвшигчдийн эрх тэгш байх нөхцөлийг ноцтой зөрчихөд хүргэв



Дүгнэлт

- УИХ-ын сонгуулийн тухай хуулийн хэвлэл мэдээлэлтэй холбоотой зүйл заалт тодорхой бус, нарийвчилсан зохицуулалтгүй, ойлгомжгүй, хоорондоо зөрчилдсөн
- Тэнцвэрт сурталчилгааны нэр томъёо тайлбарлах шаардлагатай, цаг, зай талбай, өнгө аяс, нөлөөлөл г.м



ЗӨВЛӨМЖ

- Сонгуулийн сонгуулийн сурталчилгааны эхлэх хугацааг тодорхой болгох
- Сурталчилгааны хэвлэмэл материалын хязгаарлалтыг эргэж харах буюу цуцлах
- Олон нийтийн радио телевизээр нам, эвсэл, нэр дэвшигчдэд төлбөргүй сурталчилгааны цаг хуваарилах зарчмыг өөрчлөх



ЗӨВЛӨМЖ

- Сурталчилгааны үнэ тариф ижил нөхцөлтэй байх зохицуулалтыг хийх
- Нам, нэр дэвшигчдийн дунд халз мэтгэлцээн зохион явуулах зүйл заалт оруулах
- Төлбөрт сурталчилгааны тодорхойлолт, зохицуулалтыг нарийвчлах
- Мэдээний хөтөлбөрөөр төлбөртэй мэдээ оруулах асуудлыг хориглох



ЗӨВЛӨМЖ

- Өргөн нэвтрүүлгээр сурталчилгаа хийх цагийг эргэж харах, тодорхой болгох
- Арилжааны телевизүүд төрийн буюу нийт ард түмний өмч болсон агаарын долгионыг ашиглаж үйл ажиллагаа явуулдгийн хувьд сонгуулийн сурталчилгааны үеэр сонгогчдын боловсролд зориулсан цаг хуваарилах үүрэг ногдуулах, олон нийтийн эрх ашигт илүү үйлчлэх зарчмыг тусгах



ЗӨВЛӨМЖ

- Сонгуулийн сурталчилгаатай холбоотой хууль тогтоомж, дүрэм журмын хэрэгжилтийг ажиглаж хянах механизмыг боловсронгуй болгох, хуулиар зохицуулдаг болох
- Сонгуулийн үеэр Хэвлэл мэдээллийн зөвлөлийн зардлыг төсөвт тусгах боломжтой



ЗӨВЛӨМЖ

- СЕХ-ны дэргэдэх Хэвлэл мэдээллийн орон тооны бус зөвлөлийн ажиллах журмыг шинэчилж, чадавхийг бэхжүүлэх. Тухайлбал, хэвлэл мэдээллийн тэнцвэрт сурталчилгаанд хяналт тавихад шаардлагатай техник, хүн хүчний зэрэг зохих зардлыг СЕХ-ын буюу сонгуулийн төсөвт оруулах, янз бүрийн зөрчлийг цаг алдалгүй таслан зогсоох, хариуцлага хүлээлгэх асуудлаар СЕХ, олон нийтэд хандах боломжийг өргөжүүлэх хэрэгтэй



ЗӨВЛӨМЖ

- Хууль зөрчиж ухуулга сурталчилгаа хийсэн нэр дэвшигчидтэй хариуцлага тооцох заалт байгаа хэдий я хэрэгжих механизм байхгүй, шуурхай бус учир үр дүнгүй байна.



Анхаарал тавьсанд баярлалаа

www.globeinter.org.mn

www.monitoring.mn